

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.21. №60 (60)

ҮЙЛ ЯВДАЛ

БҮХ ЦЭРГИЙН ИХ ХАР СҮЛДИЙГ ЦЭНГҮҮЛЭН ТАЙХ ЁСЛОЛ БОЛЛОО



Билгийн тооллын XVII жарны “Цөөвөр” хэмээх цагагчин үхэр жилийн зуны тэргүүн харагчин могой сарын шинийн 08-ны энэ өдөр буюу өчигдөр морин цагт Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэх тайлгын ёслол Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах Агуйт уулын оргилд боллоо.

Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэх тайлгын ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Халтмаагийн Баттулга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ө.Шижир, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын зөвлөх Л.Болд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг тэргүүтэй БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн командлалын удирдлага, бүрэлдэхүүн оролцлоо.

Ёслол, хүндэтгэлийн ажиллагаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга нар Агуйт уулын тахилгат овоонд хадаг өргөн, Бүх цэргийн Их хар сүлдийг Агуйт уулын оргилд тусгайлан зассан суудалд байрлуулснаар эхэлсэн юм.

Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэх тайлгын ёслолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны тавдугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар зарлигийн хавсралтаар батлагдсан тусгай журмын дагуу Төрийн хонжин удирдан гүйцэтгэлээ.

Бүх цэргийн Их хар сүлдийн тайлга нь монгол цэргийн оройн дээд шүтээн Бүх цэргийн Их хар сүлдээ хүндэтгэн цэнгэл баяслыг нь хөгжөөж, түүнд цэрэг эрсийнхээ эрдэм чадал, ид хав, сур хүчийг илтгэн харуулж буй ёслол хүндэтгэлийн ажиллагаа бөгөөд цэнгүүлэх тайлгыг хоёр жилд нэг удаа, цагаалах тайлгыг жилд нэг удаа хийдэг. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших туг сүлдний зохилдлоготой Агуйт уул нь Баянзүрх хайрханы салбар уул бөгөөд Чингис хааны түмэн хишигтэн цэргүүд байрлаж байсан, их хааны ташуур олдсон газар гэж түүхэнд тэмдэглэгдсэн онцлогтой газар юм.

ОРОН СУУЦ ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ ГАРДУУЛАВ



Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зарим алба хаагч, тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмад дайчдад орон сууц эзэмших эрхийн гэрчилгээ гардуулах ёслолын ажиллагаа өнөөдөр боллоо. Гэрчилгээг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Гандирваа нар гардуулан өглөө. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Алба хаагчдын хувьд орон сууц нь нийгмийн хамгааллын хамгийн чухал асуудал байдаг. Салбарын удирдлагын зүгээс энэхүү асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч ирснийг

энд хэлэх нь зүйтэй. 2020 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар байгууллагын мэдлийн орон сууцыг оршин суугчдад нь хувьчлах тухай асуудлыг шийдвэрлэж, тухайн үед нь батламж өгч байсан. Энэ хугацаанд орон сууцны ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр БХЯ-ны Барилга захиалагчийн алба, Зэвсэгт хүчний 310 дугаар ангийнхан идэвх санаачилгатай ажиллаж ирсэн. Харин одоогоос та бүхэн “СӨХ”-өө байгуулж, орон сууцаа өөрсдийн менежментээр хариуцан авч яваарай” гэсэн юм. Монгол Улсын Засгийн газрын “Орон сууц хувьчлах тухай” 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж байгууллагын мэдлийн 602 орон сууцыг ийнхүү оршин суугчдад нь нэн хөнгөлөлттэй үнээр хувьчлан өглөө.

ТӨРИЙН ДЭЭД ОДОН, МЕДАЛЬ, САЛБАРЫН ШАГНАЛААР ШАГНАВ

Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, “Монгол цэргийн өдөр” - ийг тохиолдуулан Ү Б Х И С, Цэргийн төв эмнэлэг, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, “Соёмбо” редакц, “Алдар” спорт хороо, Ц Д Б Э Ч - ын зарим бие бүрэлдэхүүн болон БХЯ, ЗХЖШ-ын Ахмадын хорооны ахмадуудад төрийн дээд одон, медаль, салбарын шагнал гардууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Зарим алба хаагчдыг төрийн дээд одон, медалиар шагнах тухай зарлиг гаргасан байна. Уг зарлигт “Улс, эх орныг батлан хамгаалах үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний зарим алба хаагчдыг Монгол Улсын төрийн одон, медалиар шагнаасугай” гэжээ. Шагналыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Гандирваа нар гардуулан өглөө. Шагнал гардсан нийт алба хаагчдад хандан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр: “Эх орноо батлан хамгаалах эрхэм үйлсэд өөрийн ухаан бодол, бие сэтгэл, хөдөлмөр бүтээлээ харамгүй зориулж, байгууллага, хамт олноо манлайлан, ажил, амжилтаараа бусдадаа үлгэр дуурайлал болж гаргасан ололт амжилт, хийж бүтээсэн ажил, хөдөлмөрөө үнэлүүлэн Төрийн дээд одон, медаль болон салбарын шагналаар шагнагдсан Та бүхэнд баяр хүргэе. Ялангуяа Цэргийн төв эмнэлгийн эмч, сувиллагч ажилтан алба хаагч та бүхэнд тусгайлан баяр хүргэж байна. Та бүгд энэ цар тахлын хүнд цаг үед үүргээ маш сайн биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байж, олон мянган хүнийг аюулт өвчнөөс аварч чадлаа. Яг одоо ч шагналаа авч чадахгүй халдварт өвчний голомтод ажлаа хийж байгаа олон эмч, сувиллагч байгаа. Та бүхэндээ баярлалаа” хэмээн онцолсон юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
18	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
26	12

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.456.00	3.516.00
CNY	441.50	444.90
RUB	38.10	39.80
JPY	25.88	26.38
KRW	2.44	2.58

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 09
2021.05.21.
/БААСАН ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ХОЁР ХАР
ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ.

Наран ургах, шингэх:

05.07-20.31

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Уул.

Аргын тооллын 5 сарын 21, Сугар гараг. Билгийн тооллын 9, Харцага одтой, шарагчин могой өдөр. Өдрийн наран 5 цаг 07 минутад мандан, 20 цаг 31 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адеугуус номхруулах, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрхээд сайн. Ургаа мод таслаха, газрын ам нээх зэрэг үйлд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоогод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Дашиямтай өдөр. Өчүүхэн дүүрэн болох улирал (3 цаг 54 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

50.618

ЭДГЭРСЭН

44.391

НАС БАРСАН

235/8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2325 (17)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

216

ЭДГЭРСЭН

2109

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 163,869,893

Эдгэрсэн

Нийт: 139,070,978

Нас барсан

Нийт: 3,398,302

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	25,741 2,495,568
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	8,133 2,858,085
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	1,234 409,180
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	639 77,570

2021.05.20

11:00 ЦАХИМ БАЙДАЛ

ХАМГААГАХ ДАВНА

ҮЙЛ ЯВДАЛ

ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА МАРШ, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУДАД ШАГНАЛЫГ НЬ ГАРДУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий цэргийн командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээний аваргуудын шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга өчигдөр Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэх тайлгын ёслолын дараа гардуулан өгч, баяр хүргэлээ.

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан энэхүү тэмцээнд ахмад Б.Цээноров (350) захирагчтай Тусгай хүчний цэргийн командлалын рот, дэслэгч Б.Отгон-Од (330) захирагчтай Тусгай хүчний цэргийн командлалын салаа, дэслэгч А.Ууганбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын салаа, ахмад Л.Саранзаяа (311) захирагчтай ЗХЖШ-ын эмэгтэй цэргийн алба хаагчдын тасаг төрөл бүртээ тэргүүн

байруудыг эзэлсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга дээрх амжилтын эздэд шагнал гардуулахаас гадна Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн захирагч, хурандаа Н.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр нарт баг, тамирчдаа бэлтгэн оролцуулж, амжилт гаргасанд баяр хүргэж, өргөмжлөл гардуулсан юм.

Цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг сорьсон энэ тэмцээн оролцогчдын тоог салаанаас рот хүртэлх бүрэлдэхүүнтэй болгон нэмэгдүүлж, тэмцээний журамд эзлэгдсэн объектыг чөлөөлөх, гранат шидэх, буудлагын шинэ төхөөрөмжүүд ашиглах зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан юм.

Хошууч генерал Д.Ганзориг: ХОЁР УЛСЫН ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХЭД ТАНЫ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР ИХ



БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Хуурай замын цэргийн атташе, ахлах хурандаа Яан Сюнийн Монгол Улсад ажиллах үүрэгт хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг өнгөрсөн лхагва гарагт хүлээн авч уулзаж, талархал илэрхийллээ. Уулзалтад тус яамны цэргийн атташе, ахлах хурандаа Бао Юйхай хамт оролцсон юм.

Хошууч генерал Д.Ганзориг “Хоёр орны цэргийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд ахлах хурандаа Яан Сюнийн оруулсан хувь хэмжээлшгүй их юм. Сүүлийн жилүүдэд хоёр улсын Зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагаа хурдацтай хөгжиж, цэргийн өндөр түвшний айлчлал, буцалтгүй тусламж, хамтарсан дадлага, боловсролын сургалт зэрэг олон хэлбэрээр өргөжиж байна. БНХАУ-ын Ардын Чөлөөлөх арми “Хааны эрэлд” энхийг дэмжих олон улсын сургуульд 2006 оноос хойш алба хаагчдаа илгээн оролцуулж, “Анчин бүргэд”, “Талын манлайлагч” сургалт, дадлагуудыг амжилттай хамтран зохион байгуулж ирснийг цохон тэмдэглэхдээ таатай байна. Хамгийн сүүлд гэхэд БНХАУ-аас

Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчдын эрүүл, аюулгүй байдалд журмын нөхрийн хувиар санаа тавьж, цар тахлаас сэргийлэх хүрээнд “Синофарм” вакцин хандивласанд талархаж буйгаа илэрхийлэе” гээд 1999-2000 онд БНХАУ-ын Тусгай хүчний сургуульд суралцаж байхдаа хятад цэргүүдийн сахилга бат, бэлтгэгдсэн байдал нь өндөр түвшинд байдгийг анзаарснаа онцоллоо. Мөн тэрээр хоёр улсын Зэвсэгт хүчний алба хаагчид өдгөө БНӨСУ-д явагдаж байгаа энхийг сахиулах ажиллагаанд нэгэн зорилготойгоор хамтран ажиллаж байгаа.

БНХАУ-ын Ардын Чөлөөлөх арми нь НҮБ-ын энх тайвныг хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоогоороо дэлхийн улс орнуудыг манлайлагчдын нэг нь байж, чухал үүрэг гүйцэтгэж байгааг тодотгоод, ахлах хурандаа Яан Сюнийн идэвх чармайлт, хичээл зүтгэлээр хоёр цэргийн хамтын ажиллагаа өргөжсөнийг онцоллоо. Уулзалтын төгсгөлд хошууч генерал Д.Ганзориг Монгол Улсад элэгтэй эрхэм ахлах хурандаагийн цаашдын ажил алба, амьдралд нь ЗХЖШ-ын даргын зөвлөлийн нэрийн өмнөөс хамгийн сайн сайхан бүхнийг хүсье гэлээ.

ШИЛДЭГ ТҮРҮҮЧ, БАЙЛДАГЧААР Э.ДЭМҮҮЛ, Ү.ДАШПҮРЭВ НАР ШАЛГАРАВ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жил болон шинэ цагийн мотобуудлагын цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 65 жилийн ой буюу “Ерөнхий цэргийн өдөр”-ийг тохиолдуулан хугацаат цэргийн алба хаагчдын дунд Цэргийн нийтлэг дүрмийн хүрээнд “Шилдэг түрүүч”, “Шилдэг

байлдагч”, сагсан бөмбөгийн аварга шалгаруулах уралдаан зарлаж, явууллаа. “Шилдэг түрүүч”-ээр дэд түрүүч Э.Дэмүүл, “Шилдэг байлдагч”-аар байлдагч Ү.Дашпүрэв нар бусдыгаа манлайлсан бол сагсан бөмбөгийн тэмцээнд артиллерийн дивизионы баг тамирчид тэргүүн байрт шалгарч, медалийн эздээр тодорсон юм.

Ахлах дэслэгч Г.АНТУЯА

“ЗАПАД-2021” СУРГУУЛЬД МОТОБУУДЛАГЫН САЛАА ОРОЛЦОНО



ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Запад-2021” стратегийн команд штабын сургуулийн хоёрдугаар шатны төлөвлөлтийн хурал энэ сарын 19-ний өдөр цахимаар явагдлаа. Төлөвлөлтийн хуралд Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөлж, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр оролцон, тус сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчин удирдлагын бүлэг, мотобуудлагын салаа оролцуулахаар болсныг

илэрхийлж, харилцан санал солилцлоо. Энэ үеэр ОХУ-ын Зэвсэгт хүчний Ажиллагааны удирдлагын газрын дарга, дэслэгч генерал А.Н.Петров сургуульд оролцогч орнуудын төлөөлөлтэй нэг бүрчлэн ярилцаж, зарим асуудлуудыг тодотгож байсан юм.

Төлөвлөлтийн хуралд ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны цэрэг, агаарын атташе, хурандаа П.Г.Анисов, БХЯ-ын ГХАГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Г.Одбаяр нарын албаны хүмүүс оролцсон юм.